



МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ СУДАЛГАА



Монголын аялал жуулчлалын зах зээлийн тойм
Аялал жуулчлалын зах зээлийн багтаамж

469,309

Монголд аялсан жуулчдын тоо /2017 он/

36%

Үзэсгэлэнт байгаль, зэрлэг ан амьтан үзэхээр ирсэн
жуулчдын нийт жуулчдад эзлэх хувь /2017 он/

\$360сая

Хувийн аяллаас олсон орлого /2017 он/

\$1760

Аяллын дундаж зардал /2015 он/

271

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аялал
жуулчлалын байгууллагын тоо

МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ:


Гадаадын жуулчдын орох урсгал онцлог

Аялал жуулчлал нь улс орны нийгэм, соёлын хөгжлийг дэмжих, сурталчлах, эдийн засгийн өсөлтийг хангахад чухал үүрэгтэй салбар бөгөөд 2016 онд дэлхийн ДНБ-ний 10.2 хувьтай тэнцэх хэмжээний буюу 7.6 триллион долларын орлого олж 292 сая ажлын байрыг бий болгосон гэсэн статистик Дэлхийн эдийн засгийн форумын тайланд тусгагджээ. Энэхүү илтгэлд дурдсанаар 2016 онд гадаадад зорчсон хүний тоо 1.2 тэрбумд хүрч аялал жуулчлалын өрсөлдөх чадвараар Испани, Франц, Герман улс тэргүүлжээ.

2017 оны “Аялал жуулчлалын дэлхийн өрсөлдөх чадварын тайлан”-д 136 орныг эрэмбэлэхэд Монгол улс 3.31 оноогоор 102 дугаар байрт (аялал жуулчлалыг тэргүүлэх чиглэл болгох 102, жуулчдын үйлчилгээний дэд бүтэц 111, байгалийн нөөц 79, соёлын нөөц болон бизнес аялал 62) эрэмбэлэгджээ. Монгол Улс хэдийгээр аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх бодлого тодорхойлж хэрэгжүүлж байгаа ч гадаадаас Монголыг зорин ирэх жуулчдын тоо төдийлөн нэмэгдэхгүй, аялал жуулчлалын өрсөлдөх чадвар сул байгаад “хүрээлэн буй орчны тогтвортой байдал”, “агаарын тээврийн дэд бүтэц”, “соёлын нөөц болон бизнесийн аялал”, “олон улсад нээлттэй байдал” зэрэг үзүүлэлтүүд шууд нөлөөлсөн болохыг өрсөлдөх чадварын үнэлгээ харуулжээ.

Эдийн засагт аялал жуулчлалын салбарын үзүүлэх нөлөөг үнэлэх нэг статистик нь төлбөрийн тэнцэл дэх уг салбарын орлогын нөлөө юм. Төлбөрийн тэнцлийн статистик үзүүлэлтээс харахад 2011 оноос хойш Монгол улсын гадаадын жуулчдаас олсон орлого нь Монголчуудын гадаадад аялахдаа зарцуулсан зардлаас бага байгаа буюу сөрөг тэнцэлтэй байна. 2017 оны хувьд 137.2 сая ам.долларын сөрөг тэнцэлтэй байгаа бөгөөд ДНБ-ний 1.23 хувьтай тэнцэх хэмжээний гадаад валютыг аялал жуулчлалын шугамаар гадаадад зарцуулсан байна.

Зураг 1. Төлбөрийн тэнцэл дэх аяллын үйлчилгээний нөлөөлөл, 2008-2017 он



Эх сурвалж: Монгол банкны төлбөрийн тэнцлийн статистик



2009-2013 онд Монгол улсын эдийн засгийн өсөлт 6 орчим хувьтай байхад аялал жуулчлалын салбар 16-29 хувийн өсөлттэй байсан нь уг салбар эдийн засгийн өсөлтөнд маш мэдрэмжтэй байсан нь харагдаж байна. Энэ нь жуулчдын тооны статистикаас ч харагдаж байна. Монгол Улсыг зорин ирэх жуулчдын тоог сүүлийн 10 жилээр тоймлон харвал 2007-2012 он хүртэл өсч байсан бол түүнээс хойш буурч 2015 онд хамгийн доод түвшин буюу 386204 болжээ¹. Харин өнгөрсөн 2 жилийн хугацаанд бага зэрэг өсч 2017 онд 469,309 жуулчин хүлээн авч 396 сая ам.долларын орлого олсон нь өнгөрсөн жилийнхээс 89 сая ам.доллараар өссөн байна².

Тухайлбал, Монгол улсын эдийн засгийн огцом өсөлт саарсан жилүүдэд буюу 2013-2015 онуудад жуулчдын тоо өмнөх онтойгоо харьцуулахад буурч харин 2016 оноос эхлэн сэргэх хандлага ажиглагдаж байна. Улирлын онцлогоос хамаарч 6-9 дүгээр саруудад хамгийн их жуулчин ирдэг ба 2017 онд Монголд аялсан жуулчдын тоо өмнөх онтой харьцуулахад 16%-аар өсч 469309-д хүрчээ.

Зураг 2. Монгол улсад аялсан жуулчдын тоо, 2002-2017 он



Эх сурвалж: YCX

Монгол Улс дэлхийн аялал жуулчлалын бүсчлэлийн дагуу Зүүн хойд Азид багтдаг бөгөөд үүнтэй холбоотойгоор эдгээр бүс нутгийн аялагчид ихэвчлэн ирдэг. Монгол Улсад ирэх жуулчдын тоо 2010 онтой харьцуулахад 2015 онд 15.32%-аар буурсан хэдий ч 2015-2017 оны хооронд 21.52%-аар өсчээ

Хүснэгт1. Монголд аялсан жуулчдын тоо, улсаар

УЛС	2010	2015	2017	2010/2015	2015-2017
БНХАУ	193730	145029	142481	-25.14%	-1.76%
Франц	7527	7989	10038	6.14%	25.65%
Япон	14140	19277	22519	36.33%	16.82%
БНСУ	42231	47213	74921	11.80%	58.69%
ОХУ	121647	70668	106885	-41.91%	51.25%
Британи	6209	6148	5996	-0.98%	-2.47%
Америк	12808	14420	16667	12.59%	15.58%
Бусад	57798	75460	89802	30.6%	19.01%
Нийт	456090	386204	469309	-15.32%	21.52%

Эх сурвалж: YCX

¹ Үндэсний статистикийн хороо

² Нийслэлийн аялал жуулчлалын газар: <http://tourism.ub.gov.mn/?p=6163>

Монголд ирэх гадаадын иргэдийн тоо жил ирэх тутам нэмэгдсээр байгаа бөгөөд 2017 онд нийт зорчигчийн 35.2%-нь жуулчлах зорилгоор ирсэн байна.


Зураг 3. Гадаад иргэдийн Монгол ирж буй аяллын зорилго, эзлэх хувиар



2016 онд хийгдсэн “Аялал жуулчлалын салбарын нийслэлийн нийгэм, соёлд үзүүлэх нөлөөллийн судалгаа”-нд хамрагдсан иргэдийн 75 хувь нь аялал жуулчлал нь нийгэм соёлийн түвшинд нөлөөлдөг ба зочид буудал, зоогийн газар, худалдаа үйлчилгээний чанар, үйлчилгээний соёл, гар урлал, бэлэг дурсгалын зүйлсийн чанар, хүртээмж зэрэгт эерэг нөлөөтэй гэсэн бол, эх хэлний дархлаа, уламжлалт ёс заншил зэрэгт нөлөө бага гэжээ. Монгол улсад ирж буй жуулчдын 70 орчим хувь нь үзэсгэлэнт байгалийг, 50 орчим хувь нь нүүдлийн соёл, уламжлалт ахуйг, 25 орчим хувь нь Монгол улсын түүх, Чингис хааны түүх, 15 орчим хувь нь адал явдалт аялал зэргийг сонирхдог. Үүнээс гадна зэрлэг амьтдын ан агнуур, загасчлал гэх мэт олон төрлийн зорилготой зочилдог байна³.

Монгол улсын аялал жуулчлалын салбарын суурь бүтээгдэхүүн нь “үзэсгэлэнт байгаль” “зэрлэг ан амьтан”, “уламжлалт зан заншил, соёл”-той танилцах аялал бөгөөд 2015 онд жуулчдын 46% нь үзэсгэлэнт байгаль, зэрлэг ан амьтанд татагдаж Монгол улсаар аялдаг байсан бол 2017 онд 36% болж буурсан байна. Харин Монголын уламжлалт зан заншил, соёлтой танилцахаар ирэх жуулчдын тоо нэмэгдсэн ба 2015 онд 22% байсан бол 2017 онд 30% болж өсчээ.

Зураг 4. Жуулчдын Монгол улсад аялсан шалтгаан, хувиар 2015, 2017 онд




Эх сурвалж: Монгол банк

³ Аялал жуулчлалын салбарын нийслэлийн нийгэм, соёлд үзүүлэх нөлөөллийн судалгааны тайлан, МИРИМ Консалтант ХХК, 2016

Монгол улсын гадаадын жуулчдаас олж буй орлого 2011 оноос хойш тогтмол өссөн үзүүлэлттэй байна. 2017 онд хувийн аяллаас нийт 360 сая ам.долларын орлого олсон ба 2016 онтой харьцуулахад 24%-иар нэмэгджээ. Үүнд Монгол улсын бодит эдийн өсөлт, инфляцийн дундаж түвшин, валютын ханш зэрэг эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдээс гадна ирж буй гадаадын жуулчдын тоо нөлөөлсөн байна.


Зураг 5. Гадаадын жуулчдаас олсон орлого, аяллын зорилгоор



Эх сурвалж: Монгол банкны төлбөрийн тэнцлийн статистик

Хувиараа аялагчдын зардлын дийлэнх хувийг тээвэр болон зочид буудлын зардал эзэлж байна. Харин цаашдаа төрөөс баримталж буй бодлого, зохицуулалтын нөлөөгөөр дотоодын тээвэрт зарцуулж буй зардал буурах хандлагатай бөгөөд бараа болон үзвэр үйлчилгээнд зарцуулах зардал өснө гэсэн урьдчилсан таамаг байна.

Зураг 6. Хувиараа аялагчдын зардлын бүтэц



Эх сурвалж: Монгол банк 2015 он

Монголд аялж буй жуулчин дунджаар 20-25 төрлийн салбараас үйлчилгээ авдаг учир аялал жуулчлалаас олж буй орлого олон салбараар дамжин эдийн засагт ордог. Хувийн аяллаас олж буй орлогын ихэнх хувийг аяллын үйлчилгээнээс олж буй орлого эзэлдэг бөгөөд 2017 онд 348 сая ам.долларын орлого олсон байна.


Хүснэгт 2. Хувийн аяллаас олсон орлогын задаргаа, 2010-2017, сая ам.доллар

он	Эрүүл мэнд	Боловсрол	Олсон орлого
2010	0	4	209
2011	1	5	138
2012	1	5	165
2013	2	5	187
2014	2	7	200
2015	2	8	230
2016	3	7	280
2017	4	8	348

Эх сурвалж: Монгол банкны төлбөрийн тэнцлийн статистик

Аялал жуулчлалын байгууллагаар дамжуулан багцын аяллаар аялж буй гадаадын жуулчдын зардлын 72%-ийг багцын аяллын төлбөр, 8%-г бараа бүтээгдэхүүний худалдан авалт, 7%-г дотоодын тээврийн зардал тус тус эзэлдэг байна. Үүнээс гадна багц аялагчдад Аялал жуулчлалын байгууллагуудын санал болгож буй бүтээгдэхүүний төрөл болон чанар хангалтгүй байгаагаас жуулчдын давтан ирэлт буурдаг байна.

Зураг 7. Багц аялагчдын зардлын бүтэц



Эх сурвалж: Монгол банк 2017 он

Гадаадын жуулчдын Монгол улсад аялахдаа зарцуулж буй аяллын дундаж зардлын хэмжээ 2011 онтой харьцуулахад 2015 онд 11%-аар буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд үүнд Монгол улсын жилийн инфляц-ийн түвшний өөрчлөлтөөс гадна валютын ханшны тогтворгүй байдал нөлөөлсөн байна. Тухайлбал 2011 онд Монгол улсын инфляц-ийн түвшин 8.9 хувьтай байсан бол 2015 онд 1.9 хувьтай байсан байна.

Хүснэгт 3. Монголд ирж буй гадаад жуулчдын аяллын дундаж зардал, улсаар, ам.доллар

 УЛС	Аялалын дундаж зардал				Дундаж зардал		Зардлын харьцаа		2011 2015
	Багц аялал		Хувийн аялал		2011	2015	2011	2015	
	2011	2015	2011	2015					
АНУ, Канад	3194	3009	1356	2148	2170	2570	2.4	1.4	18%
БНСУ	1433	1565	1046	1549	1312	1557	1.4	1.0	19%
Франц	2356	2048	1483	2040	2138	2044	1.6	1.0	-4%
Япон	3709	1338	624	1213	3113	1274	5.9	1.1	-59%
Баруун европ	2829	1357	1532	1369	2546	1363	1.8	1.0	-46%
Британи	2672	1914	1230	1249	2179	1575	2.2	1.5	-28%
Бусад	3138	2412	878	1487	1604	1940	3.6	1.6	21%
Дундаж	2761.6	1949.0	1164.1	1579.3	2151.7	1760.4	2.7	1.2	-11%


Эх сурвалж: Монгол банк 2011, 2015

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖ:

Аялал жуулчлалын болон үйлчилгээний байгууллагын чадавх

1990-ээд оны зах зээлийн эдийн засагт шилжих үйл явцтай зэрэгцэн олон тооны аялал жуулчлалын байгууллага шинээр байгуулагдсан ба хувийн хэвшлийн байгууллагууд чөлөөт өрсөлдөөний зарчмаар ажиллаж аялал жуулчлалын салбарыг хөгжүүлж, улс орноо гадаадад сурталчлан гадаадын жуулчдын ирэх урсгалыг нэмэгдүүлж ажиллаж байна. 2017 оны байдлаар жуулчлалын төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх ангиллын гэрчилгээтэй 271 аялал жуулчлалын байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ба 2016 онтой харьцуулахад энэ тоо 18%-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


Зураг 8. Тур оператор компаниудын ангилал, 2017 он



Эх сурвалж: Монголын аялал жуулчлалын холбоо

2016 онд нийт 150 гаруй байгууллага хүсэлт ирүүлснээс 94 байгууллага шинээр гэрчилгээ авч, 135 байгууллага сунгалт хийлгэсэн байна.


Зураг 9. 2016 онд гэрчилгээ шинээр авсан болон сунгалт хийлгэсэн аялал жуулчлалын байгууллага, компаниудын тоо



Эх сурвалж: Монголын аялал жуулчлалын холбоо

2017 онд 180 гаруй байгууллага хүсэлт ирүүлснээс 111 байгууллага гэрчилгээ шинээр авч, 160 байгууллага сунгалт хийлгэсэн байна.

Зураг 10. 2018 онд гэрчилгээ шинээр авсан болон сунгалт хийлгэсэн аялал жуулчлалын байгууллага, компаниудын тоо



Эх сурвалж: Монголын аялал жуулчлалын холбоо

2017 оны байдлаар Монгол улсад аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 1800 орчим үйлчилгээний байгууллага байгаа бөгөөд дийлэнх хувь нь төвийн бүсэд харьяалагддаг байна. Үүнээс үйлчилгээний байгууллагын төрлөөр нь авч үзвэл жуулчны баазын тоогоороо Хөвсгөл аймаг, зочид буудлын тоогоороо Өмнөговь аймаг, рашаан сувиллын тоогоороо Төв аймгууд тус тус тэргүүлж байна.

Хүснэгт 4. Аймгуудын үйлчилгээний газруудын тоон мэдээлэл, 2017 он

		Жуулчны бааз	Зочид буудал	Амралтын газар	Гэр буудал	Мотел дэн буудал	Рашаан сувилал
Төвийн бүс	Улаанбаатар	109	154	0	0	136	0
	Сэлэнгэ	10	40	16	0	0	2
	Зуунмод	36	5	15	0	0	33
	Дархан	0	27	8	0	16	2
	Дорноговь	6	26	60	14	0	3
	Дундговь	10	5	0	3	9	1
	Өмнөговь	25	59	3	31	0	3
Хангайн бүс	Архангай	26	29	0	0	0	0
	Өвөрхангай	30	11	6	31	7	4
	Баянхонгор	6	11	8	3	34	6
	Булган	17	3	83	0	10	2
	Эрдэнэт	0	26	5	0	16	0
	Хөвсгөл	74	16	0	130	14	17
Баруун бүс	Баян-Өлгий	8	5	0	0	0	0
	Увс	8	7	3	4	2	3
	Ховд	3	8	2	2	10	2
	Говь-алтай	3	7	2	2	40	3
	Завхан	10	10	0	0	5	5
Зүүн бүс	Дорнод	0	8	11	1	19	0
	Хэнтий	15	34	7	0	0	2
	Сүхбаатар	6	26	60	14	0	3
НИЙТ		495	507	284	232	284	86

Эх сурвалж: Жуулчны мэдээллийн төв

Аялал жуулчлалын мэргэшсэн байгууллага болон үйлчилгээний газрын тоо жил бүр өсөн нэмэгдэж байгаа нь манай улсад аялал жуулчлалын салбар хөгжих нөхцөл бүрдэж байгааг харуулах нэг үзүүлэлт мөн боловч аялалын дэд бүтэц хөгжөөгүй, үйлчилгээний байгууллагуудын чадавх сул, тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүй, жуулчны баазуудын үйлчилгээний стандарт дээшилж тогтворжоогүй, аялал жуулчлалын бүс нутгуудад хэт ачаалал үүссэн зэрэг нь аялал жуулчлалын хөгжилд сөрөг нөлөөтэй гэсэн нийтлэг дүгнэлтүүд гарсан байна.